

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын ерөнхий газар

2025 оны эхний хагас жилийн байдлаар

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
Засгийн газрын тогтоол							
1	<u>2024.01.03</u> <u>№02</u> <u>Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай</u>	2	<u>Төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах</u>	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 7,447.91 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 худалдан авах ажиллагааг тусган Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 3 худалдан авах ажиллагааг зохион байгууллахад нийт 5 удгаа тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулсан. Үүнд: - “Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ” үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын баримт бичиг 2 удаа, - “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах” тендер шалгаруулалтын баримт бичиг 2 удаа, - “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн гарын авлага, танилцуулга хэвлүүлэх” тендер шалгаруулалтын баримт бичиг 1 удаа Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 3 худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, хуулийн хугацаанд нийт 12 оролцогчоос тендерийн материал хүлээн авсан.			

				Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 6 худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог байгуулагдсан ба үнэлгээний хорооны хурлыг нийт 14 удаа зохион байгуулсан. “Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах” тендерт тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг хангасан тендерийг оролцогчид ирүүлээгүй тул тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд дахин зохион байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн гарын авлага, танилцуулга хэвлүүлэх” тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн Адмон принт ХХК нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг хангасан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.			
2	<u>2024.12.18</u> <u>№221</u> <u>Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай</u>	1	Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлж, батлагдсан төсвийн хүрээнд тооцож олгох	Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар батлуулж 505.6 мянган иргэний тэтгэврийн нэмэгдэлд 300.1 тэрбум төгрөгийг зарцуулж, дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөгт хүрсэн.			
3	<u>2024.12.25</u> <u>№231</u>	1	Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр,	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй			

	<u>Итгэлцүүр батлах тухай</u>		тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2025 онд хэрэглэх батлагдсан итгэлцүүр, дээд хэмжээг мөрдөж ажиллах	уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө” гэж заасны дагуу Засгийн газрын газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Итгэлцүүр батлах тухай” 231 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Бодлогын даалгавар хүргүүлэх тухай” 01/2769 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төвд тэтгэврийн программд өөрчлөлт оруулах бодлогын даалгавар хүргүүлэв. Уг бодлогын даалгаврын дагуу Мэдээллийн технологийн төв тэтгэврийн программд өөрчлөлт оруулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгохоор сонгосон цалин, хөлсийг итгэлцүүрээр өсгөн тогтоолгох нөхцөлийг бүрдүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.			
4	<u>2024.06.06 №254 Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам батлах тухай</u>	1	<u>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах</u>	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 тэрбум хүртэлх төгрөгөөр баталсан. Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2025 онд хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжаагаар худалдаалж байгаа тул “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д нээлттэй арилжаанд оролцох зохицуулалтыг нарийвчлан тусгах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулан Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээд байна.			

				Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, 08 дугаар тогтоолоор банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 700.0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр нэг жилийн хугацаатай байршууллаа. Энэ талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон пэйж хуудсаар мөн https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлсэн. Мөнгөн хадгаламжийн эхний 2 сарын хүү болох 17.1 тэрбум төгрөгийг хүлээн авч нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөөд байна. Энэхүү хадгаламжийн хугацаанд нийтдээ 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгө өсөж арвижих боломжийг бүрдүүлэн ажилласан.			
5	<u>2024.06.06</u> <u>№256</u> <u>Тэтгэврийн нөөц</u> <u>санд хөрөнгө</u> <u>төвлөрүүлэх,</u> <u>бүртгэх,</u> <u>хуваарилах,</u> <u>байршуулах,</u> <u>мэдээлэх,</u> <u>хөрөнгө оруулах,</u> <u>өвлүүлэх, хяналт</u> <u>тавих журам</u> <u>батлах тухай</u>	1	<u>Тэтгэврийн нөөц</u> <u>санд хөрөнгө</u> <u>төвлөрүүлэх,</u> <u>бүртгэх,</u> <u>хуваарилах,</u> <u>байршуулах,</u> <u>мэдээлэх,</u> <u>хөрөнгө оруулах,</u> <u>өвлүүлэх, хяналт</u> <u>тавих.</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар зохицуулсан. Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө, төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам”-ыг баталсан. Тэтгэврийн нөөц санд 2024, 2025 онуудад улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй ба тэтгэврийн			

				даатгалын санд төлөгдсөн шимтгэлийн орлогоос арилжааны 4 банк дахь (ХААН, Голомт, ХХБ, Төрийн банк) тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд 2024 онд 212.3 тэрбум төгрөг, 2025 онд нэмж 25.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээр нийтдээ 1,047,204 даатгуулагчийн 237.3 тэрбум төгрөгийг байршуулаад байна. Тэтгэврийн нөөц сангийн үлдэгдэл 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар (харилцахын дансны үлдэгдэлд тооцсон хүүг нэмж тооцсон) 243.2 тэрбум төгрөг байна. Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг даатгуулагч бүрээр бүртгэн мэдээллийг даатгуулагчдад “Нийгмийн даатгал” аппликейшн, https://portal.ndaatgal.mn/ системээр мөн E-mongolia аппликейшний “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал” цэсээр нийтэд ил тод мэдээллэн ажилласан.			
6	<u>2024.09.25</u> <u>№96</u> <u>Жагсаалт</u> <u>шинэчлэн батлах</u> <u>тухай</u>	1	Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем”-д тогтоосон хугацаанд байршуулах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу мэдээллийг байршуулж байгаа эсэхэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Тус хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэмжээнд 93.4 хувийн гүйцэтгэлтэй, мөн мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр дүгнэхэд дундаж 92.8 хувьтай үнэлэгдэж тодорхой үр дүнд хүрсэн байна. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд нээлттэй мэдээлэл байршуулахтай холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит,			

				мониторингийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02/259 дугаар зөвлөмжийг хүргүүлж ажиллав. Нийгмийн даатгалын байгууллага Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/137 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын статистик мэдээллийн маягтын дагуу жилийн эцсийн болон эхний хагас жилийн статистик мэдээллийг гарган Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн, нээлттэй өгөгдөл цэсэд байршуулан ажиллаж байсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж байгаатай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны А/175 дугаар тушаалаар нийгмийн даатгалын статистик мэдээллийн албан ёсны маягыг шинэчилж, жилийн эцсийн байдлаар Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр баталсаны дагуу 2024 оны жилийн эцсийн статистикийн мэдээллийг гарган 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/1170 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Уг батлагдсан маягтын дагуу тоон мэдээллийг нээлттэй өгөгдөлд байршуулахаар ажиллаж байна.			
7	<u>2024.10.02</u> <u>№109</u> <u>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ батлах тухай</u>	2	Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд	Засгийн газрын 2024 оны “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-ний хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажиллаа. Үүнд: 1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө”-г 2025 оны 03 дугаар сард хэлэлцэн баталж уг төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын салбарын “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлах, сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулахаар тусгав.			

			дэмжлэг үзүүлж ажиллах	Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө”-г Төрийн албаны зөвлөлийн “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” дэд системд байршуулав. 2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд 2 гомдол, 1 мэдээллийг иргэн, албан хаагч, ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн. Үүнээс: 1 гомдол, 1 мэдээллийг шалгаж дүгнэлт гаргаснаас нэг нь Ёс зүйн зөрчил гаргасан, нэг нь ёс зүйн зөрчилгүй гэж дүгнэгдсэн бөгөөд 1 гомдол нь хяналтын шатанд үргэлжилж байна. 3. Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нэг гишүүн сургагч багшаар, Дэд хорооны дарга болон нэг гишүүн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцов. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав. Уг хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж танхим, цахим, дадлага хосолсон сургалтад нийт 130 гишүүн хамрагдав. 4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар “Төрийн албан хаагч бид” гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, 30 нэгжийн цахим хуудаст байршуулан түгээв.			
8	<u>2025.02.26</u> <u>№109</u> <u>Ажил, амралтын</u> <u>цагийн</u> <u>зохицуулалтын</u> <u>тухай</u>	1	Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сарын баярын 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа,	Монголын үндэсний уламжлалт Цагаан сарын баярын өдрүүдээр амарсан 2025 оны 03 дугаар сарын 03-ны Даваа гарагийн ажлын өдрийг, 03 дугаар сарын 04-ний Мягмар гарагийн ажлын өдрийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/57 дугаар тушаалаар 03 дугаар сарын 16-ны өдрийн Ням гарагт, 03 дугаар сарын 25-ны өдрийн А/71 дүгээр			

			Мягмар, Лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах	тушаалаар 03 дугаар сарын 29-ний өдрийн Бямба гарагт тус тус аймаг, дүүргийн салбарын хэмжээнд шилжүүлэн ажиллуулав.			
9	<u>2025.04.16</u> <u>№192</u> <u>Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай</u>	1	<u>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 тэрбум хүртэлх төгрөгөөг баталсан.</u>	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр тус тус баталсан. Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2025 онд хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжаагаар худалдаалж байгаа тул Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д нээлттэй арилжаанд оролцох зохицуулалтыг нарийвчлан тусгах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулан Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээд байна.			
10	<u>2025.06.04</u> <u>№279</u> <u>Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай</u>	1	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяраар 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16.17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийх тухай Засгийн газрын 279 дүгээр тогтоолын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Ажил, амралтын өдөрт зохицуулалт			

			амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах	хийх тухай” А/188 дугаар тушаалаар 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд нөхөн ажиллав.			
Хэсгийн дундаж:							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
11	2025.01.14 №3 “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” –ын хэрэгжилтийн талаар	1	2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах	1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Сургалт зохион байгуулах тухай” 2025 оны А/07 дугаар тушаал, НД-10/25 дугаартай “Сургалтын гэрээ”-нд үндэслэн үндэсний Монгол бичгийн сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 93 албан хаагчийг хамруулан, 2025 оны 01 дүгээр сарын 13-наас 02 дугаар сарын 26-ны өдрийн хооронд танхимаар зохион байгуулав. Сургалтыг “Тарвалин хийд”-ийн дэргэдэх шашины сургуулийн үндэсний монгол бичгийн багш Б.Базаррагчаа заан, нийт 20 удаагийн хичээл буюу 40 академик цагийн сургалтаар Монгол бичгийн үүсэл, үндсэн болон нэмэлт зурлага, тоо бичих, эгшиг үсэг, эгшиг зохицох ёсон, зөөлөн, хатуу дэвсгэр үсгийн дүрэм, үсэг холбох, төсгөх дүрэм, гадаад үг тэмдэглэх, дагавар, тийн ялгалын нөхцөл, монгол бичгийн фонт суулгах, ашиглах, дадлага ажлуудыг гараар бичих, компьютерээр бичих, гэрийн даалгавар, багаар ажиллуулан, тухай бүр шалган үнэлгээ өгч ажиллав. Нийт албан хаагчид дундаас дээш түвшинд Монгол бичигтэй болсон. НДЕГ-аас албан бичиг, тушаалыг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн Монгол бичгээр давхар хөтлөн явуулж байна.			
Хэсгийн дундаж:							
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ							
12	2024.09.06 №07 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс	1	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн			

	<u>урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам батлах тухай</u>		хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих	2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г батлуулав. Төлөвлөгөөнд 2025 оны эхний хагас жилд 28 арга хэмжээ зохион байгуулахаар тусгагдсанаас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 10 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 631.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 18 арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах ажил журмын дагуу явагдаж байна.			
13	<u>2024.11.08 №08</u> <u>Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай</u>	1	<u>Чингис хаан банк ХХК-ийн 5,070,600,000 төгрөгийн үнэлгээтэй 3 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авах</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024.11.08-ны өдрийн "Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай" 08 дугаар тогтоолын дагуу 2025 оны эхний хагас жилд Чингис хаан банкнаас 5.07 тэрбум төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан. Чингис хаан банкнаас өр төлбөр хөрөнгө хүлээн авах талаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: - Чингис хаан банкнаас 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Өр төлбөрт хөрөнгө санал болгох тухай” ГЗ/100 дугаар албан бичгээр 2.55 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 8 ширхэг хөрөнгийг өр төлбөрт тооцон шилжүүлэх санал ирүүлсэн. Тус банкнаас “Хөрөнгө эстимэйт үнэлгээ” ХХК-аар гүйцэтгүүлсэн хөрөнгийн үнэлгээний тайланг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр цахимаар авч, өр төлбөрт санал болгосон хөрөнгүүдийн төлөв байдалтай газар дээр нь очиж танилцан, дээрх хөрөнгүүдийг 2.42 тэрбум төгрөгийн өр төлбөрт тооцон шилжүүлэн авах саналыг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай”			

			07/1336 дугаар албан бичгээр тус банканд хүргүүлсэн. - Чингис хаан банк ХХК-иас 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” ГЗ/247 дугаар албан бичгээр дээрх хөрөнгүүдийг 2.42 тэрбум төгрөгийн өр төлбөрт тооцон шилжүүлэхээр харилцан тохиролцож, Газрын даргын зөвлөлийн хурлаар 2.42 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн өр төлбөрт тооцон авахыг дэмжсэн тул 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/1492 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын танилцуулга, тогтоолын төслийг хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 06/5705 дугаар албан бичгээр Капитал банк ХХК-иас нэхэмжилсэн өр төлбөрт тооцон шилжүүлэн авах боломжтой хөрөнгийн жагсаалтыг тус газарт ирүүлсэн. Дээрх хөрөнгүүдийг судалж үзээд Хан-Уул дүүргийн 25-р хороо, Буянт ухаа хороолол /17120/, наадамчдын зам гудамж 323, 325, 327 байрнуудад байршилтай орон сууцны зориулалттай 4 ширхэг хөрөнгө, автозогсоолын зориулалттай 5 ширхэг хөрөнгийг өр төлбөрт санал болгох үнэ болон хөрөнгийн үнэлгээний тайлан, холбогдох мэдээллийг гаргуулахаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хүсэлт хүргүүлэх тухай 01/998 дугаар албан бичгийг Банкны эрх хүлээн авагчид хүргүүлэн, Банкны эрх хүлээн авагчаас 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 467 дугаар албан бичгээр дээрх хөрөнгүүдийн үнэлгээний тайлан болон холбогдох мэдээллийг ирүүлсэн. Банкны эрх хүлээн авагчаас ирүүлсэн “Арвижих Эстимейт Үнэлгээ” ХХК-аар гүйцэтгүүлсэн үнэлгээний тайлан, холбогдох мэдээллийг судалж дээрх 9 ширхэг хөрөнгийг 1.21 тэрбум төгрөгийн өр төлбөрт тооцон шилжүүлэхээр харилцан			
--	--	--	--	--	--	--

				тохиролцож, Газрын даргын зөвлөлийн хурлаар 1.21 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 9 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн өр төлбөрт тооцон авахыг дэмжсэн тул 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/1492 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын танилцуулга, тогтоолын төслийг хүргүүлсэн.			
14	<u>2025.01.27</u> <u>№01</u> <u>Нэрийн данс</u> <u>нээх, бүртгэх,</u> <u>хөтлөх,</u> <u>даатгуулагчийн</u> <u>гарааны</u> <u>үлдэгдлийг</u> <u>тооцох журам</u> <u>батлах тухай</u>	1	Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцох	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.34 хувь байхаар тогтоож, Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны саналыг тус тус авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны “Санал хүргүүлэх тухай” 01/965 тоот албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хүүг баталсны дараа хүү тооцох, даатгуулагчдад мэдээлэх ажлыг зохион байгуулна.			
15	<u>2025.02.27</u> <u>№05</u> <u>Мөнгөн</u> <u>хадгаламжийн</u> <u>2025 оны хүүгийн</u> <u>доод хэмжээ</u> <u>батлах тухай</u>	1	<u>Нийгмийн</u> <u>даатгалын</u> <u>сангийн чөлөөт</u> <u>үлдэгдлийг</u> <u>банкны системд</u> <u>нөлөө бүхий</u> <u>арилжааны</u> <u>банканд</u> <u>байршуулах</u> <u>мөнгөн</u> <u>хадгаламжийн</u> <u>2025 оны хүүгийн</u> <u>доод хэмжээг</u>	Энэ тогтоол Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 08 дугаар тогтоолоор хүчингүй болсон.	Хасуулах саналтай		Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор хүчингүй болсон тул

			жилийн 11.40 хувиар баталсан.				
16	<u>2025.02.27</u> <u>№06</u> <u>“Үйлдвэрлэлийн</u> <u>осол, мэргэжлээс</u> <u>шалтгаалсан</u> <u>өвчний</u> <u>даатгалын</u> <u>сангаас</u> <u>санхүүжүүлэх,</u> <u>урьдчилан</u> <u>сэргийлэх арга</u> <u>хэмжээний 2025</u> <u>оны төлөвлөгөө”</u> <u>батлах тухай</u>	1	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г батлуулав. Төлөвлөгөөнд 2025 оны эхний хагас жилд 28 арга хэмжээ зохион байгуулахаар тусгагдсанаас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 10 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 631.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 18 арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах ажил журмын дагуу явагдаж байна.			
17	<u>2025.02.24</u> <u>№07</u> <u>Хөрөнгийн</u> <u>хэмжээг тогтоох</u> <u>тухай</u>	1	<u>Нийгмийн</u> <u>даатгалын</u> <u>сангийн чөлөөт</u> <u>үлдэгдлээс</u> <u>банкны системд</u> <u>нөлөө бүхий</u> <u>арилжааны</u> <u>банканд 2025</u> <u>онд хадгаламж</u> <u>хэлбэрээр</u> <u>байршуулах</u> <u>мөнгөн</u> <u>хөрөнгийн дээд</u> <u>хэмжээг 700.0</u> <u>тэрбум төгрөгөөр</u> <u>тогтоосон.</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр баталсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 700.0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр нэг жилийн хугацаатай байршуулан тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан. Энэ талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон пэйж хуудсаар мөн https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлсэн. Мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу 5, 6 дугаар сарын хүү болох 17.1 тэрбум төгрөгийг хүлээн авч			

				нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөөд байна. Энэхүү хадгаламжийн хугацаанд нийтдээ 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгө өсөж арвижих боломжийг бүрдүүлсэн.			
18	<u>2025.03.24</u> <u>№08</u> <u>Мөнгөн</u> <u>хадгаламжийн</u> <u>2025 оны хүүгийн</u> <u>доод хэмжээ</u> <u>шинэчлэн батлах</u> <u>тухай</u>	1	<u>Нийгмийн</u> <u>даатгалын</u> <u>сангийн чөлөөт</u> <u>үлдэгдлийг</u> <u>банкны системд</u> <u>нөлөө бүхий</u> <u>арилжааны</u> <u>банканд</u> <u>байршуулах</u> <u>мөнгөн</u> <u>хадгаламжийн</u> <u>2025 оны хүүгийн</u> <u>доод хэмжээг</u> <u>жилийн 14.20</u> <u>хувиар шинэчлэн</u> <u>баталсан.</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 08 дугаар тогтоолоор банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаатай мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулсан. Энэ талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон пэйж хуудсаар мөн https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлсэн. Мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу 5, 6 дугаар сарын хүү болох 17.1 тэрбум төгрөгийг хүлээн авч нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөөд байна. Энэхүү хадгаламжийн хугацаанд нийтдээ 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгө өсөж арвижих боломжийг бүрдүүлсэн.			
Хэсгийн дундаж:							
Нийт дундаж:							

Хэрэгжилтийг хянасан:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН

ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)
тамга, тэмдэг

/...../
(Б.ГАНХУЯГ)

/...../
(огноо)

Хэрэгжилт тайлагнасан:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал)

/...../
(С.ЭНХЗУЛ)

/...../
(огноо)